

<https://doi.org/10.5564/spej.v46i37.2564>

Монгол Улсын нутаг дэвсгэр дээрх шашны үйл явц (социологийн судалгааны үр дүнгээр)

Religious processes on the territory of Mongolia (Based on the results of sociological research)

Дашковский Петр Константинович¹

Доктор (Sc.D), профессор
Алтай их сургуулийн Оросын ба үндэстний
шашин судлал, төр-шашны харилцааны
тэнхмийн эрхлэгч, угсаатан-соёл ба шашин
судлалын лабораторийн эрхлэгч, Барнаул
(ОХУ) dashkovskiy@fpn.asu.ru

Магсаржавын Гантуяа^{1, *}

Доктор (Sc.D), профессор
Шинжлэх Ухааны Академий
Философийн хүрээлэн
Шашин судлалын салбар
gantuyam@yahoo.com

Шершнева Елена Александровна^{1, *}

Доктор (Ph.D), дэд профессор
Алтай Их сургуулийн Оросын ба үндэстний
шашин судлал, төр-шашны харилцааны
тэнхмийн дэд профессор.
D2703@yandex.ru

Dashkovskiy Petr Konstantinovich¹

Doctor (ScD), professor
Head, Department of regional Studies of
Russia, national and state-confessional
relations, head of the laboratory of
ethnocultural and religious studies of the Altai
state university, Barnaul (Russia).
dashkovskiy@fpn.asu.ru.
<https://orcid.org/0000-0002-4933-8809>

Gantuya Magsarjav^{*}

Doctor (ScD), professor
Department of Religious Studies,
Institute of Philosophy,
Mongolian Academy of Sciences
gantuyam@yahoo.com

Shershneva Elena Alexandrovna^{*}

Candidate of Historical Sciences, Associate
Professor, Associate Professor of the
Department of Regional Studies of Russia,
National and State-Confessional Relations,
Altai State University. D2703@yandex.ru/
<https://orcid.org/0000-0001-6766-6438>

¹ © Зохиогчид. 2022. Сэтгүүлд нийтлэгдсэн эрдэм шинжилгээний бүтээл нь зохиогчдийн оюуны өмч байх бөгөөд (CC BY- <https://creativecommons.org/licenses/by/4.0/>) нөхцөлийн хүрээнд ашиглана уу.

* Холбоо барих зохиогч. Бүх зохиогч тэгш оролцоотой

Хураангуй:

Энэхүү өгүүлэлд Орос-Монголын хамтарсан төслөөс 2020-2021 онд Монгол Улсын нутаг дэвсгэрт хийсэн социологийн судалгааны үр дүнг танилцуулж байна. Судалгааны явцад Монгол Улсын нутаг дэвсгэр дэх шашны нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, тус улсын иргэд шашны үйл ажиллагаанд хэрхэн оролцож байгаа болон төрөөс явуулж буй шашны бодлого ямар байгааг тодорхойлох оролдлого хийсэн.

Судалгаанд оролцогчдын үзэж байгаагаар шашин хоорондын харилцан ойлголцлыг бий болгох үүднээс шашны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих нь төрийн чухал үүрэг байх ёстой. Монголын нийгэмд шашны уламжлалтай холбоотой хэвшмэл ойлголт давамгайлж байгаа нь тодорхой байна. Тиймээс судалгаанд оролцогчдын дийлэнх нь шашны туйлиралын илрэлийг гол төлөв Исламын шашинтай холбож үзжээ. Нөгөө талаар, Монгол Улсад ертөнцийг үзэх хэт туйлирсан өрөөсгөл үзэл харьцангуй бага гэдгийг тэмдэглэн хэлэх хэрэгтэй

Түлхүүр үгс: соёлын амьдрал, буддын шашин, шашны уламжлал, шашны туйлирал, үндэсний соёл

Abstract:

The article presents the results of a sociological study conducted by the Russian-Mongolian project in 2020 on the territory of Mongolia. In the course of the study, an attempt was made to assess the religious situation on the territory of Mongolia and to identify the degree of involvement of the country's residents in religious life, as well as their perception of state confessional policy.

According to respondents, an important role in building interfaith dialogue should be played by the state, whose task is to control the activities of religious organizations. It is established that stereotypes associated with religious traditions prevail in Mongolian society.

Thus, the majority of respondents associate Islam with manifestations of extremism. At the same time, it should be noted that Mongolia is a country with a fairly low level of extremist worldview. The assessment of the development of the interfaith situation in Mongolia requires further observation.

Keywords: State & Confessional politics, Buddhism, religious identity, religiosity, extremism, confessions

I. Оршил

Социалист гэгдэж байсан улс орнууд шашин шүтлэгийн аливаа илрэлийн эсрэг тэмцэж ирсэн социализмын бүтээн байгуулалтын үедээ ертөнцийг үзэх атеист үзлийг үе шаттайгаар төлөвшүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж байсан бол 1990-ээд оноос эдгээр улс орнуудад улс төрийн бүтцийн өөрчлөлт бий болсонтой уялдан оюун санааны сэргэн мандалт, оюун санааны эрх чөлөөний зарчмуудыг хэрэгжүүлэхийн төлөө зүтгэж эхлэв. XX зууны сүүлээр эхэлсэн энэ үйл явц Монгол Улсыг ч тойроогүй юм. Улс оронд өрнөсөн ардчилсан өөрчлөлтүүд нь шашны олон ургальч үзлийг бий болгож, төр, шашны харилцааны шинэ тогтолцоо үүсэхэд хүргэсэн билээ. Өнөө үед шашны харилцааг зохицуулах төрийн бодлого нь Монгол Улсын эрх зүйн баримт бичигт тусгагдсан оюун санааны эрх чөлөөний зарчмуудыг баримтлахад голлон чиглэж байна[1;2].

Сүүлийн арваад жилийн турш Орос, Монголын эрдэмтэд хамтран Монголын нутаг дэвсгэрт болж буй угсаатны шашны нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж байна. Энэхүү судалгааны хүрээнд 2020-2021 онд Монгол Улсын нутаг дэвсгэрт социологийн судалгааг шинээр хийсэн. Судалгаанд дараах гол зорилтуудыг дэвшүүлсэн билээ. Үүнд: тус улсын хүн амын шашинд хандах хандлагыг тогтоох; асуулгад оролцогчдын шашны үйл явц дахь

оролцооны түвшинг илрүүлэх, шашин хоорондын төлөв байдал, төр, шашны харилцааг бий болгоход засгийн газрын гүйцэтгэх үүргийг дүгнэх гэсэн зорилт тавьлаа.

Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтаршил, засаг захиргаа нутаг дэвсгэрийн хуваарийг харгалзан улсын төв хэсгээс 300-аас доошгүй судалгаанд хамрагдагсдаас ярилцлага авахаар тогтлоо. Социологийн судалгааны хүрээнд өөр өөр нас, хүйс, үндэс угсаа, мэргэжлийн 362 (100%) хүнээс бодит асуулга авчээ.¹ Үүний зэрэгцээ улсын нийслэл, хамгийн том хот болох Улаанбаатар хотод Монгол орны өнцөг булан бүрээс ирсэн (байнгын болон түр хугацаагаар) ажиллаж, сурч, амьдарч байгаа иргэд оролцсоныг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Нийт судалгаанд оролцогчдыг 5 бүлэгт хуваасан. 16-21 насны 73 хүн (20%), 22-35 насны 78 хүн (22%), 36-45 насны 54 хүн (15%), 46-60 насны бүлэг - 96 хүн (27%), 61-ээс дээш насны хүмүүс - 61 хүн (17%). Түүврийг (давхраажилт, нутаг дэвсгэр, санамсаргүй байдлаар) төлөөлөл болгон авсан болно.


II. Судалгааны арга зүй

Хүн амын шашин шүтлэгийн байдал. Монгол Улсын иргэдийн шашинд хандах хандлагыг тодорхойлохын тулд судалгаанд оролцогчдоос «Хүн сүсэг бишрэлтэй байх нь чухал гэж та бодож байна уу?» гэсэн асуултад хариулт авав. Судалгаанд оролцогчдын 73% (263 хүн) үүнд эерэг хариулт өгсөн бол 12% (44 хүн) сүсэг бишрэлийг хүн бүрийн амьдралд зайлшгүй байх зүйл гэж үздэггүй ажээ, 15% (55 хүн) асуултад хариулахаас түдгэлзжээ. Гэхдээ хүн бүрийн амьдралд шашин чухал болохыг судалгаанд оролцсон бүх насныхан онцолж байсныг тэмдэглэх нь зүйтэй. Монгол Улсын нутаг дэвсгэр дэх шашны үйл явцын социологийн мониторингийн арван жилийн хугацаанд нийгмийн амьдралд шашны үүрэг тодорхой хэмжээгээр тогтворжиж байгаа нь ажиглагдаж байна. Хэрэв бид шинэ судалгааны үр дүнг Монгол улсад хийгдсэн өмнөх судалгаатай харьцуулбал[3;4], шашин шүтлэг хүний амьдралын чухал үзэгдэл биш гэж үздэг хүмүүсийн хувь мэдэгдэхүйц буурч байгааг ажиглаж болно. Гэвч судалгаанд хамрагдагсдын 60 хувь нь (218 хүн) шашны баяр ёслолыг гэртээ тэмдэглэдэггүй гэсэн дүн гарчээ. Иймээс Монголын нийгэм дэх шашин шүтлэг нь үндсэндээ хүн амын ядаж нэгээхэн хэсэгт нь хэлбэрдэл төдий байна гэж үзэж болно. Энэхүү хандлагыг Монгол Улсад өрнөж буй улс төрийн өөрчлөлтийг дагаад энэ бүс нутгийг дэлхийн улс төр, соёлын нийгэмлэгт нэгтгэх гэсэн хандлагатай зэрэгцээд угсаатны соёлын өвөрмөц байдлаа хадгалж үлдэх гэсэн үйл явцтай холбон тайлбарлаж болно[5]. Шашныг Монголын үндэсний соёлын салшгүй нэг хэсэг гэж үздэг билээ.

Тус бүс нутагт хийсэн судалгаанд хамрагдагсдыг шашны харьяаллаар нь авч үзснийг Зураг 1-т харуулсан бүдүүвчээр үзүүлэв.

¹ Асуулгыг доктор М.Гантуяа удирдан, төслийн судлаачид (МУИС-ийн багш доктор Д.Оюунгэрэл, С.Дэмбэрэл нар) гүйцэтгэв.

Зураг 1. Монгол дахь санал асуулгад оролцогчдын шашны харъяалал




Түүхэн үйл явцаар бүрэн тодорхой тайлбарлагддаг Монгол орны нутаг дэвсгэр дэх Буддын шашны зонхилох байр суурийг дээрх бүдүүвч зургаас харж болно. Гэсэн хэдий ч 2016 онд хийсэн судалгаатай харьцуулахад бөө мөргөлийг дагагчдын хувь буурсан байгааг тэмдэглэх нь зүйтэй[6]. Энэ баримтыг мөн тус улсад Буддын шашин өргөн дэлгэрч байгаатай холбон тайлбарлаж болно. Төрөөс Буддизмыг Монголын уламжлалт соёл, түүхийн нэг хэсэг хэмээн байр сууриа илэрхийлдэг. Үндэсний соёлын үнэт зүйлсийг сурталчлах арга хэмжээг идэвхтэй явуулж байгаа бөгөөд үүнд Буддын шашны үнэт зүйлс чухал үүрэг гүйцэтгэдэг. Буддын шашны үнэт зүйлийг хадгалах чиглэлээр явуулж буй засгийн газрын идэвхтэй байр суурь нь Буддын шашныг албан бус байдлаар төрийн шашны сататустай болгож байна[7]. Бидний гаргаж буй тоо баримтыг өмнөх судалгаануудтай харьцуулж үзвэл монголчуудын ахуй амьдралд Буддизмын гүйцэтгэх үүрэг тодорхой хэмжээгээр нэмэгдсэнийг тэмдэглэх нь зүйтэй. 2016-2018 оны социологийн судалгааг эргэж харахад, тухайн үед Төв болон Баруун Монголд амьдарч байсан судалгаанд оролцогчдын дөнгөж 57.6 хувь нь Буддын шашныг дагаж байсныг санах хэрэгтэй[8].

Энэхүү судалгааныхаа хүрээнд бид шашинд татагдах, шашны үйл ажиллагаанд оролцох, шашны чиг хандлагыг дагах гэсэн үзүүлэлтээр шашин шүтлэгийн онцлог болон түвшинг үнэлэхийг оролдлоо. Судалгаанд оролцогчид сүм хийд, мөргөлийн газруудад хэр олон удаа очдог, мөн шашны зан үйлийг гэртээ үйлддэг эсэх зэрэг асуултын хариултаас сүсэг бишрэлийн гүн, гүехний түвшинг тогтоож болно. Судалгаанд оролцогчид "Та сүм хийдэд (мөргөлийн газарт) хэр олон удаа очдог вэ" гэсэн асуултад хэрхэн хариулсныг Зураг 2-т харуулав.

Судалгаанд хамрагдагсад сүсэг бишрэлийн газарт очих нь заавал байх албагүй гэж үзсэн байх бөгөөд энэ саналтай судалгаанд оролцогчдын бүх насны төлөөлөл нэгдэж байгаа нь дээрх диаграмаас харагдаж байна. Ямартай ч,

шашин шүтлэгийн хэрэгцээгээ хангахын тулд шашин-мөргөлийн газруудад очихыг хоёрдугаарт тавьдаг аж. Эс бөгөөс, судалгаанд оролцогчид шашин-мөргөлийн газруудад илүү олон удаа, системтэй очихыг эрмэлзэх байв. Судалгаанд хамрагдагсдын дийлэнх нь шашин-мөргөлийн газар заавал очих шаардлагагүй гэж үзэж байгаа ч судалгаанд оролцогчдын 40% (143 хүн) шашны дэг жаягийг сахих шаардлагатай гэж хариулжээ. Гэсэн хэдий ч судалгаанд оролцогчдын нэлээд их хувь буюу 31% (112 хүн) нь шашны дэг жаягийг сахихын ач холбогдлыг тодорхойлж чадаагүй юм. 16-45 насны судалгаанд оролцогчид шашны дэг жаягийг сахин биелүүлэхэд бага ач холбогдол өгч байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Зураг 2. Судалгаанд оролцогчдоос шүтлэгийн объектод очсон байдал




16-45 насны судалгаанд оролцогчдын 37% (76 хүн) ийм бодолтой байгаа бол 46 ба түүнээс дээш насны хүмүүс зөвхөн 19% (31 хүн) шашны зан үйл хийх нь чухал гэж үздэггүй ажээ. Үүний зэрэгцээ судалгаанд оролцогчдын 40% (146 хүн) зөвхөн баяр ёслолын үеэр л шашны зан үйл хийдэг, 22% (79 хүн) огт шашны зан үйл хийдэггүй байна. 2016 оны судалгаатай харьцуулахад асуулгад оролцогчид томоохон баяруудын үеэр шашны уламжлалыг сахьдаг байдал тодорхой хэмжээгээр буурчээ[9]. Монголын хүн ам шашны зан үйлийг сахин биелүүлэх нь оюун санааны соёлын салшгүй хэсэг гэж үзэж болно[10]. Өнөө үед шашин шүтлэгийн өвөрмөц байдлын хэрэгцээг онцлох хандлага ажиглагдаж байна. Энэ үзэгдэл дэлхийн бүх орон газарт илэрч байгаа бөгөөд үүгээр тодорхой хүн ам өөрийгөө албан бус байдлаар аль нэг шашинд хамааруулдаг[11]. Ийнхүү судалгаанд оролцогчдын дийлэнх нь өөрсдийгөө сүсэгтэн гэж тодорхойлсон ч шашны үйл ажиллагаанд маш бага оролцдог ажгуу.

Монголд сүсэгтэн олны дунд Буддын шашныг дагагч нар зонхилж байгаа хэдий ч, тус улсад өрнөсөн ардчилсан өөрчлөлтүүд нь янз бүрийн шашны

урсгалыг дэлгэрүүлэх нөхцлийг бүрдүүлсэн юм. Бид социологийн судалгааныхаа нэг хэсэг болгон судалгаанд оролцогчдоос ямар шашны чиг хандлагыг мэддэг болохыг тодруулахыг хүссэн юм. Судалгаанд оролцогчдоос энэ асуултад өгсөн хариултын дүнг Зураг 3-т үзүүлэв.

Доорх тоо баримтаас харахад, судалгаанд оролцогчид тухайн бүс нутгийн уламжлалт шашнуудаас гадна шинэ шашны урсгалуудыг ч мэддэг болохыг харж болно. Гэхдээ шинэ шашнуудтай танилцсан хувь хэмжээ тийм ч их биш байна. Үүний зэрэгцээ Буддизм, Ислам, Үнэн алдартан, Католик шашин, бөө мөргөл шүтэгчдийн хойноос судалгаанд оролцогчдын харьцангуй их хувь (7%) нь Баптизм гэх мэт Протестант урсгалын талаар мэддэгээ тэмдэглэжээ. Нэмж хэлэхэд, 16-21 насны залуучуудын нэлээд хувь (8%) нь (Энэтхэгийн Хинду шашны) Вишну уламжлалыг мэддэг болох нь харагдаж байна.

Зураг 3. Судалгаанд оролцогчдыг шашны нийгэмлэгүүдтэй танилцах



III. Судалгааны үр дүн

Шашин хоорондын харилцаа. Шашин хоорондын харилцааны динамик нь янз бүрийн хүчин зүйлтэй, үүнд гэр бүл, гэрлэлтийн харилцаа ч нөлөөлдөг. Судалгаанаас үзэхэд, 39% (141 хүн) өөр шашны хүнтэй гэрлэхийг зөвшөөрчээ. Харин 38% (137 хүн) шашин хоорондын гэрлэлтийг эсэргүүцэж, 23% (84 хүн) энэ асуултад хариулахад хэцүү гэж үзсэн байна. Энэ баримт нь өөр итгэл үнэмшлийн төлөөлөгчдөд болгоомжтой хандаж байгааг харуулж байна. 16-45 насны судалгаанд оролцогчид өөр шашны төлөөлөгчийг гэр бүлдээ хүлээн авахад бэлэн байгаагаа илэрхийлсэн бол 46-60 насны судалгаанд оролцогчдын

52 хувь нь (96 хүнээс 50 нь) шашин хоорондын гэрлэлтийг эрс эсэргүүцжээ. Мөн 290 хүн (80%) гэр бүлд нь өөр шашны хүн байхгүй гэж хариулсныг тэмдэглэх нь зүйтэй. Өөр шашны хүнтэй гэрлэх тухайд, судалгаанд оролцогчид Католик шашныг илүүд үздэг (санал асуулгад оролцогчдын 57%), Үнэн алдартны шашин хоёрдугаарт (санал асуулгад оролцогчдын 26%) байна. Исламын уламжлалыг дагагсадтай санал асуулгад оролцогчдын 25%, Протестантизмыг дагагчтай 18% нь гэрлэхийг дэмжжээ. Ийнхүү Монголын иргэдийн хувьд гэрлэлтийн асуудал дээр Христийн шашныг дагагчид хамгийн сонирхолтой байр суурьтай байна. Ардчилсан шинэчлэл эхэлснээр тус улсад янз бүрийн шашны хөдөлгөөний төлөөлөл бий болж эхэлсэн бөгөөд үүний дотор Христийн шашны сурталчлан номлох үйл ажиллагаа арвин туршлагатай ажээ. Христийн шашны номлогчдын идэвхтэй байр суурь нь Христэд итгэгчийг дэвшилтэт, орчин үеийн хүн гэж төсөөлөхөд хүргэж байна. Үүнтэй холбоотойгоор монголчууд Христийн шашны уламжлалыг хамгийн “сэтгэл татам” гэж үздэг болжээ. Тэрчлэн шинэчлэлийн шатанд байгаа орчин үеийн Монгол Улс ардчиллын зарчмуудыг монгол түмний уламжлал, үнэт зүйлийг хадгалах хандлагатай хослуулахыг эрмэлзэж байгааг тэмдэглэх нь зүйтэй. Хилийн нээлтэй байдал нь тус улсын хүн амын дотор даяаршлын үйл явц болон Өрнийн соёлын уламжлал хөгжихөд нөлөөлсөн юм[11]. Үүний үр дүнд Монголын хүн амын дотор Христийн шашныг Өрнийн соёлыг тээгч гэсэн утгаар онцгойлон сонирхогчид буй болов. Үүний зэрэгцээ, энэ цаг үед тус улсын хүн амын дийлэнх нь шашин хоорондын гэрлэлтээс зайлсхийж, үндэсний соёл, уламжлалаа хадгалахыг хичээсээр байгаа юм.

Монгол Улсын нутаг дэвсгэр дэх шашин хоорондын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхийн тулд иргэд өөр шашны хүмүүстэй холбоо тогтооход хэр хялбар байдаг вэ гэсэн асуултыг тавьлаа. Чингэхүл, судалгаанд оролцогчдын 37% нь өөр шашин шүтлэгтэй хүмүүстэй холбоо тогтооход “хялбар” гэсэн хариултыг сонгосон бол 32% нь “хэцүү гэхээсээ илүү хялбар” гэж хариулжээ. 16-21 насны судалгаанд оролцогчдын дийлэнх нь өөр шашны уламжлалтай хүмүүстэй харилцаа тогтоох “хамгийн хялбар” гэсэн хариултыг сонгосон байна. Өөрөөр хэлбэл, энэ насны судалгаанд оролцогчдын 81% (59 хүн) өөр шашны төлөөлөгчтэй амархан холбоо тогтоож чадна гэж тэмдэглэжээ. Хариултын ийм хуваарилалт нь Монголын хүн ам, ялангуяа залуу үеийнхэн бусад шашны уламжлалын төлөөлөгчдөд нэлээд хүлээцтэй хандаж байна гэж дүгнэх боломжийг бидэнд олгож байна[12].

Бүх насны бүлгийн судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу 55% (199 хүн) нь бусад шашны төлөөлөгчидтэй зөрчилдөггүй гэж тэмдэглэсэн байна. Харин судалгаанд оролцогчдоос зөрчилтэй хамгийн их тулгардаг шашин хэмээн Ислам (санал асуулгад оролцогчдын 39%) болон Католик шашныг (санал асуулгад оролцогчдын 38%) онцлон тэмдэглэв. Ийнхүү ерөнхийдөө Монголын хүн ам бусад шашны бүлгүүдийн төлөөлөгчдөд эерэг хандлагатай болох нь ажиглагдаж байна. Үүний зэрэгцээ өөр шашны уламжлалыг дагагчтай гэрлэхээс татгалзах нь хүн амын үндэс угсаагаа хадгалах эрмэлзэлтэй холбоотой гэж үзэж болно, энэ тохиолдолд Монгол дахь Буддизмыг Монголын соёлын салшгүй хэсэг гэж үздэг ажгуу.

Зөрчил үүсэж болох шалтгааны хувьд судалгаанд оролцогчид Зураг 4-т тусгагдсан дараах хүчин зүйлсийг тэмдэглэв. Доорх тоо баримтаас, монголчуудын хувьд үндэс угсаа нь шашны зөрчил үүсэх гол шалтгаан биш гэж үздэгийг харж болно. Судалгаанд оролцогчдын 17% нь шашин шүтлэгт хандах хандлагыг шашны мөргөлдөөний шалтгаан болж болно гэж үзсэн нь анхаарал татаж байна. Мэдээжийн хэрэг, шашны зөрчилдөөний шалтгаан нь янз бүр байж болох бөгөөд тэдгээр нь ихэвчлэн хүмүүсийн хоорондын харилцааны хүрээнд үүсдэг. Үүнтэй холбогдуулан судалгаанд оролцогчдын 27% нь шашин хоорондын мөргөлдөөний тодорхой шалтгааныг тогтооход хэцүү гэж хариулсан нь тохиолдлын хэрэг биш ээ.


Мөн монголчууд шашин шүтлэгт онцгой ач холбогдол өгдөггүй нь шашин хоорондын зөрчилдөөнөөс зайлсхийх боломжийг олгодог гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Тухайлбал, 2019 оны есдүгээр сард Улаанбаатар хотод нийгмийн ялгарлыг (тусгаарлалтыг) тогтоох судалгааны үр дүнд монголчууд “титэм” болсон шашны төлөөлөгчдөд хүйтэн ханддаг нь тогтоогджээ[13]. Гэхдээ Монголын хүн амын дийлэнх нь Буддын шашныг үндэсний соёлын салшгүй хэсэг гэж үздэг. Дээр нь нэмж хэлэхэд, төрөөс Буддын шашинд дэмжлэг үзүүлдгээс үүдэн ихэнх судалгаанд оролцогчид өөрсдийгөө хэлбэр төдий байдлаар энэ шашинд хамаатуулдаг байна. "Титэм" болсон шашны төлөөлөгчдөд хүйтэн хандлагатай байгааг тухайн шашны уламжлалд хүн амын оролцоо бага, зөвхөн хэлбэр төдий үндэслэлээр өөрсдийгөө энэ шашинд хамаатуулдагтай холбон тайлбарлаж болно.

Зураг 4. "Бусад шашны төлөөлөгчидтэй зөрчил үүсэж болох шалтгаан юу вэ?" гэсэн асуултын хариулт.



Монгол Улсын хүн амын шашин шүтлэг харьцангуй нэг хэвийн бүтэцтэй байгаагаас сүүлийн жилүүдэд тус улсын нийт хүн амын дотор шашин шүтлэгээрээ дарамтлагдах үзэгдэл гараагүй шалтгааныг тайлбарлаж болно[14]. Энэ хандлага хадгалагдсаар байгаа нь манай энэхүү судалгаанаас харагдаж байна. Тухайлбал, судалгаанд оролцогчдын 78 хувьд (283 хүн) шашин шүтэх эрх нь хэзээ ч зөрчигдөж байсангүй гэсэн хариулт өгөв. Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа өөр өөр шашны төлөөлөгчдөд ийм хандлагатай байгаа нь судалгаанд оролцогчдын амьдарч буй бүс нутгийн шашны өнөөгийн нөхцөл байдлаас хамаарч байгаа бөгөөд үүнийг Зураг 5-д харуулав.

Зураг 5. Судалгаанд оролцогчдын Монгол дахь шашны байдлын талаарх үнэлгээ



Гэсэн хэдий ч, судалгаанд оролцогчдын нэлээд хувь нь Монгол дахь шашны нөхцөл байдлыг тийм ч тогтвортой биш, бүр зөрчилтэй гэж дүгнэжээ. Монголчуудын дийлэнх нь Буддын шашныг үндэсний өвөрмөц соёлын салшгүй хэсэг гэж үздэгтэй энэ хандлага холбоотой байж болох юм. Тухайлбал, Монгол улсын нутаг дэвсгэр дээр шинэ шашин шүтлэгүүд бий болсныг хүн амын нэг хэсэг нь монголчуудын уламжлалт соёлын үзэл баримтлалыг устгах нөхцөл гэж үзэж байна.

IV. Дүгнэлт

Ингээд Монгол Улсын нутаг дэвсгэрт хийсэн судалгааг товч тоймлон судалсны үр дүнд дараах дүгнэлтийг хийж байна. Орчин үед Монголын нутаг дэвсгэр дэх шашин шүтлэгийн бүрэлдэхүүн нь нэлээд нэгэн хэвийн байгаа хэдий ч судалгаанд оролцогчдын дийлэнх нь янз бүрийн шашны төлөөлөгчид, тэр дундаа шинэ шашны хөдөлгөөнүүдтэй танилцжээ. Буддын шашны тэргүүлэх байр суурийг соёл, түүхийн үйл явцын аль алинаар нь тодорхойлж болно, мөн шашны байр сууриараа олон улсын харилцаанд ороход бэлэн байгаа Монгол

Улс өөрийгөө Буддын шашинтай улс гэдгээр нэр хүндээ хадгалах гэсэн тус улсын төрийн удирдлагын сонирхлоор ч тайлбарлаж болно. Ийнхүү Монгол Улс өөрийгөө шашингүй улс гэж үздэг ч, манай судалгаанд оролцогчдын үзэж байгаагаар Буддын шашин бол Монголын төр засагт онцгой нөлөө үзүүлдэг аж. Шашин хоорондын харилцааны асуудал онцгой анхаарал татаж байна. Тус улсын шашны төлөв байдлыг туйлын тогтвортой гэж үзэх боломжгүй гэдгийг санал асуулгад оролцогчид тэмдэглэв.

Төрөөс тодорхой шашныг дэмжиж байгаагаас тус улсын дотор шашны тэнцвэргүй байдал үүсэж болох юм. Шашны тогтворгүй нөхцөл байдал байгаа хэдий ч, Исламын шашны хэт даврагч үзэлтнүүдтэй зарим талаар холбогдсон ч, судалгаанд оролцогчдын дийлэнх нь Монгол Улс терроризмын аюул багатай орон гэж үзжээ. Нэмж хэлэхэд, тус улсын нутаг дэвсгэр дээр аливаа шашинд хүлээцтэй хандаж байгааг тэмдэглэх нь зүйтэй. Исламын шашны хэт даврагч үзэлтнүүдтэй холбогдсоныг нийгэмд хэвшмэл үзэл ойлголт хадгалагдсаар байна гэж дүгнэж болно. Шашин шүтлэгтэй холбоотой зөрчилдөөн маш ховор байдгийг судалгаанд оролцогчид тэмдэглэв. Өөр шашны төлөөлөгчтэй гэрлэх тохиолдолд судалгаанд оролцогчид Христийн шашинтнуудыг илүүд үзэж байгаа нь харагдав. Тус улсад ардчилсан шинэчлэл өрнөж эхэлснээр энэ шашны төлөөллийг монголчууд орчин үеийн дэлхий нийтийн шаардлагад нийцсэн хамгийн дэвшилтэт шашин гэж үзэж байгаа бололтой. Үүний зэрэгцээ манай судалгаанд хамрагдагсдын дунд Буддын шашны уламжлал давамгайлж, ядахдаа л өөрийгөө энэ шашинтай хэлбэр төдий боловч холбож байгаа нь үндэсний онцлогоо хадгалж үлдэх гэсэн хүсэл эрмэлзэлтэй нь холбоотой ажгуу.

Санхүүжилт. Энэхүү судалгааг «*XIX – XXI зууны эхэн үеийн Сибирийн болон Монголын тодорхой бүс нутаг дахь шашны нөхцөл байдалд угсаатан соёлын ба улс төрийн үйл явцын нөлөө*» сэдэвт Орос-Монголын суурь судалгааны хамтарсан төслийн хүрээнд гүйцэтгэв (Төслийн дугаар 20-59-44004).

Ашигласан материал

1. Рованова И.В., Зимин О.И., Жуков А.В., Жукова А.А. (2015). Религиозное мифотворчество в политической жизни современной Монголии // Вестник ЗабГУ. №4. стр. 96. 95–102
2. Сабиров Р.Т. (2020). Монгольский буддизм в XXI веке: в процессе конструирования // Государство. Религия. Церковь. №1(38). Стр. 86–105, 112
3. Дашковский, Кушнерик, Цэдэв Н. (2009). Некоторые особенности этноконфессиональной ситуации в Баян-Ульгийском аймаке Монголии. Барнаул, ОХУ. 242 дэх тал
4. Дашковский П., Цэдэв Н., Шершнева Е. (1). Некоторые особенности этноконфессиональной ситуации в Баян-Ульгийском аймаке Монголии. *НАРОДЫ И РЕЛИГИИ ЕВРАЗИИ*, 4(4), 180-186. извлечено от <http://journal.asu.ru/wv/article/view/2355>
5. Ермакова Ю.А., Каратеев Д.Е., Лучихина Е.Л., Демидова Н.В. (2017). Динамика активности болезни, функционального статуса и рентгенологических изменений при раннем ревматоидном артрите: результаты 5-летнего наблюдения в рамках российской программы РАДИКАЛ. *Научно-практическая ревматология*. 168. <https://doi.org/10.14412/1995-4484-2015-17-23>

6. Дашковский, П., Цэдэв, Н., & Шершнева, Е. (2017). Некоторые особенности этноконфессиональной ситуации в Баян-Ульгийском аймаке Монголии. *НАРОДЫ И РЕЛИГИИ ЕВРАЗИИ*, 4(4), стр. 417. извлечено от <http://journal.asu.ru/wv/article/view/2355>
7. Сабиров Р.Т. (2012). Буддизм в Монголии на рубеже XX–XXI вв. // Вестник Калмыцкого института гуманитарных исследований РАН. №3. С. 95–100
8. Цэдэв Н., Монхбат А. (2019). Об этноконфессиональной ситуации в Монголии // Современные этнические процессы на территории центральной Азии: проблемы и перспективы. стр. 112–115
9. Дашковский П.К., Шершнева Е.А., Цедев Н. (2017). Влияние государственной политики на этнорелигиозные процессы в Монголии (по результатам социологических исследований) // Мир Большого Алтая. 2017. №3. С. 414–427
10. Гусев И., Терентьев В.И. (2020). Состояние религиозной жизни Улан-Батора (на примере района Баянзурх) // Православие и дипломатия в странах Азиатского–Тихоокеанского региона. Материалы X Международной научно-практической конференции. Улан-Удэ, стр. 43-47
11. Железняков А.С., Литвинова Т.Н. и др. (2016). Россия и Монголия: цивилизационные аспекты модернизации (сравнительный анализ) / отв. ред. А.С. Железняков, Т.Н. Литвинова. Москва: Институт социологии РАН. –196. с. 80
12. Цэдэв Н.Х., Монхбат А.Д. (2019). Об этноконфессиональной ситуации в Монголии // Современные этнические процессы на территории центральной Азии: проблемы и перспективы. стр. 113
13. Гусев И., Терентьев В.И. (2020). Состояние религиозной жизни Улан-Батора (на примере района Баянзурх) // Православие и дипломатия в странах Азиатского–Тихоокеанского региона. Материалы X Международной научно-практической конференции. Улан-Удэ, стр. 45-46
14. Дашковский П.К., Цэдэв Н., Шершнева Е.А. (2010). Некоторые особенности этноконфессиональной ситуации в Баян-Улгийском аймаке Монголии // Мировоззрение населения Южной Сибири и Центральной Азии в исторической ретроспективе: сборник статей / под ред. П.К. Дашковского. Барнаул: Азбука. Вып. IV. стр. 183

Бусад эх сурвалж

1. Гантуяа М. “Орчин үеийн монголчуудын шашин шүтлэгийн байдал” илтгэл // “Дэлхийн шашин судлалын чиг хандлага ба Монголын шашин судлал” ОУЭШХ. 2014-01-16. МУИС. Улаанбаатар
2. Гантуяа М. Монголчуудын шашин, соёлын онцлог байдал: уламжлал ба шинэчлэл // Философи, Шашин судлал, Volume number: 18 (451). УБ 2016
3. Горохов С.А. Религиозная идентичность как фактор формирования конфессиональных регионов современного мира // Вестник московского университета. 2012. Сер. 5. География. № 5. стр. 49–55.
4. Дашковский П.К., Кушнерик Р.А., Цэдэв Н. Этноконфессиональные процессы в Северо-Западной Монголии (по материалам полевых исследований 2008 г.) // Политологические и этноконфессиональные исследования в регионах. Барнаул: Изд-во Алт. ун-та, 2009. Т. II. С. 241-246.
5. Ермакова Т.В. Российские и монгольские ученые о современной Монголии // Новые исследования Тувы. 2015. №3. стр. 168–172

6. Жуков А.В., Зимин О.И., Жукова А.А. Глобализация и возрождение буддизма в Монголии // Девятые Байкальские международные социально-гуманитарные чтения. Иркутск, 12-24 января 2015 г. Иркутск, 2016. стр. 34–39
7. Сабиров Р.Т. Буддизм в Монголии на рубеже XX–XXI вв. // Вестник Калмыцкого института гуманитарных исследований РАН. 2012. № 3. стр. 95–100
8. Четырова Л.Б. Роль буддизма в конструировании этничности калмыков и монголов // Четвертые востоковедные чтения памяти О. О. Розенберга. Доклады, статьи, публикации документов / РАН, Ин-т восточных рукописей; сост. М.И. Воробьева-Десятовская, Е.П. Островская; ред. Т.В. Ермакова. СПб, 2011. стр. 190–198